**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 07 өдөр Дугаар А/286 Ховд

# Эзэмшил газрын хэмжээ, талбай өөрчлөх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, 2016 оны 55 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 10 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Жаргалан багийн иргэн Бэгзжавын Даваасүрэн /ФБ56123116/-ийн, 3 дугаар гудамжны 5 тоотод байрлах 1818.0 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 1646.0 метр квадрат, хаягийг Орчлон 2 дугаар гудамжны 203 тоот болгон, зориулалтыг склад, худалдаа үйлчилгээний болгон өөрчлөн 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2. Газрын хэмжээ талбай өөрчлөгдөж байгаа аж ахуй, нэгж байгууллагад газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх баталгаажсан аж ахуй, нэгж байгууллагад газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ

Zax A/286 Ch

02 01413